

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Европын эмэгтэйчүүдийн төлөөх залбирал2

Өнөөдөр 50 сая орчим хүн боолчлогдож байна. Худалд агдсан бэлгийн боолууд тэдний дунд хамгийн түгээмэл байдаг бөгөөд үүний үр дүнд дэлхий даяар сая сая эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгт өртөж байна. АНУ-ын Төрийн департаментын 2023 оны тайланд зөвхөн 2021 онд л гэхэд Герман руу худалдаалагдсан 44,722 хохирогчийн 93 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд ихэнх нь Болгар, Румыниас ирсэн байна. Хохирогч эмэгтэйчүүд эрх чөлөөгөө олж, Бурханы тэдэнд өгсөн итгэл найдвараар амьдрахын тулд хамтдаа залбирцгаа.




카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь ээ, дайны улмаас Европын орнууд руу дүрвэхээр нөхөр, гэр орноо орхин явсан Украины эмэгтэйчүүд, тэдний гэр бүл тайвшруулж, хүчирхэгжүүлж, хамгаалаарай. (Дуу. 59:16)
2. Аав аа, хүүхдүүд нь гэмт хэргийн бүлэглэлд орсноос болж, гэр бүл хамаатан санда нь заналхийлэлд өртсөн Шведийн гэр бүлүүдийг хамгаалах болтугай. Хүүхдүүд нь эрх чөлөөтэй болох болтугай. (Дуу. 32:7)
3. Эзэн минь, Испани дахь Нууц эрдэнэс нэвтрүүлэгийг бүтээж байгаа манай багт мэргэн ухааныг өгөөч, Энэ нэвтрүүлэгээр дамжуулан бэлгийн мөлжлөгт өртсөн олон эмэгтэйчүүдэд хүрэх болтугай. (Иохан 8:36)
4. Бурхан минь, манай Сербийн баг нийгмийн сүлжээ болон дижитал платформын үйлчлэлээр дамжуулан олон эмэгтэйчүүдийн амьдралд хүрэхэд туслаач. Найдвартай доторх эмэгтэйчүүд хөтөлбөрүүдээр дамжуулан олон

эмэгтэйчүүд Таныг хайж, Библиээр дамжуулан амьдралынхаа удирдамжийг олоход урам зориг өгөх болтугай. (Дуу. 90:17)

5. Аав аа, ОХУ-ын Хойд Кавказын бүс нутаг дахь ТWR-н ажилтан Надеждагийн Эмэгтэйчүүдийн үйлчлэлийн сонсогчдын асуултад хариулахын тулд сүнслэг зөвлөгч, сайн дурын ажилтнуудыг өсгөж, удирдан чиглүүлэх болтугай. (Сур. 2:6)
6. Португалийн эдийн засгийн байдал хүнд байна. Олон гэр бүл хоол хүнс, байрны мөнгөө ч төлж чадахгүйгээс зарим нь майханд амьдрахаас өөр аргагүйд хүрч байна. Бурхан минь, бид тэдэнд Таны нигүүлсэнгүй тусламжийг гүйн үйлж байна. (Дуу. 34:6)
7. Бид донтолод автсан Польш дахь залуучуудын төлөө залбирч байна. Эзэн минь, тэд сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж авч, авралыг олох болтугай. (Ром. 13:14)
8. Аав аа, Румын дахь "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг сонсдог хүмүүсийн сүнслэг хэрэгцээг бодитоор илэрхийлэх сэдэв, зочдыг сонгоход удирдагчдад Та мэргэн ухааныг өгөх болтугай. (Флп. 4:9)
9. Эзэн минь, Норвеги эмэгтэйчүүдэд өөрсдийнхөө жинхэнэ үнэ цэнийг ойлгоход нь туслаач, завгүй амьдралдаа Тантай харилцах харилцаагаа тэргүүнд тавихад туслаач. (Ром. 12:2)
10. Аав аа, Македон дахь цыган болон мусульман эмэгтэйчүүдийг хамарсан "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлэгийг хэрхэн хийх талаар та удирдагчдад удирдамжийг өгөх болтугай. (Иаков 1:5)
11. Нидерландын. Хүн амын гуравны хоёр нь өөрсдийгөө Христэд итгэгч биш хэмээн тодорхойлж байна. Тиймээс Христэд итгэгч эмэгтэйчүүд эргэн тойрныхоо хүмүүст сайн мэдээг хуваалцах эрх чөлөөг Та өгөөч (Ром. 1:6)
12. Аав аа, Евроод хүний наймаа болон бэлгийн мөлжлөгт өртөж, амьд үлдсэн эмэгтэйчүүдтэй ажилладаг Нуугдсан эрдэнэс тэдгээр хүмүүст тусалж, тэднийг урамшуулж, Христ дотор шинэ мөн чанараа олж авахад нь туслах дараагийн алхмыг хийх урам зоригийг өгөөч хэмээ н залбирч байна. (Сур. 3:5-6)
13. Дэлхийн 14 орны Найдвар доторх эмэгтэйчүүд баг, хөтөлбөр, төслүүдийг дэмжихэд тусалдаг Герман дахь хандивлагчдын төлөө Эзэн Таныг бид магъя. (Ис. 12:4)



14. Бурхан Аав аа, бид Францад биеэ үнэлэгчид үйлчилдэг Христэд итгэгч эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэд сайн мэдээг чөлөөтэй тунхаглах хүчийг Та өгөөч. (Иохан 8:9-11)
15. Сэтгэцийн болон бие махбодийн хүчирхийлэлд өртсөн Финлянд эмэгтэйчүүдийг Эзэн минь Та хамгаалаач. Тэд тусламж хайж, олох болтугай, хамтран амьдарч буй эр нөхрүүд тэднийг хайрлах болтугай. (Еф. 5:25)
16. Аав аа, Гренландын хүмүүс уур хилэн, хүсэл тэмүүлэл, үй гашуугаа Таны өмнө тайлж, эдгэрэх болтугай. Тэд цөхрөл тэмцлийг ялахын тулд Таны гэрэл тэдний дээр гэрэлтэх болтугай. (Дуу. 55:22)
17. Бурхан минь, Скандинав болон Нидерландын TWR байгууллагуудын хөгжүүлж буй шинэ Фарси хэл дээрх програм үнэний төлөө өлсөж буй иранчуудад сайн мэдээг тунхаглах болтугай. (Мат. 5:6)
18. Эзэн минь, сэтгэлийн түгшүүр, өөртөө итгэх итгэл багатай, стресс, сэтгэцийн өвчтэй Данийн бүх эмэгтэйчүүд Таны эдгэрэл, амар амгалан, оршихуйг хүлээн авах байх болтугай. (Ис. 57:18-19)
19. Эзэн минь, Хорват дахь манай зохицуулагч болон багийн сүнсэлг амьдрал Таны дотор улам гүнзгийрэх болтугай. Тэдэнд өгсөн Таны ивээл Хорватын эмэгтэйчүүдэд мөн урсан очих болтугай. (Кол. 1:9-10)
20. Аав аа, цөөнх болсон Бельги дэх Христэд итгэгчдийг хүчирхэгжүүлж, урамшуулаач. Итгэлийнхээ улмаас үүссэн бэрхшээлийг даван туулахад нь тэдэнд туслаач. (Иохан 16:33)
21. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний төвд үйлчилдэг Албани улсын багтай хамтран ажиллаж буй байгууллагуудын төлөө Бурхан Таныг магтъя. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хамгаалах байрнаас гармагцаа Христэд итгэж, орон нутгийн сүмд хамрагдах болтугай. (Иохан 13:34-35)
22. Бурхан минь, бид стресс, түгшүүр, сэтгэцийн өвчтэй Испани эмэгтэй нэг бүрийн төлөө залбирдаг. Тэд тантай уулзаж, танаас амралтыг авах болтугай. (1 Петр 5:7)

23. Эзэн минь нөхрөөсөө нууцаар айж эмээн "Эрхэм хайрт" нэвтрүүлгийг орос хэлээр сонсдог эмэгтэйчүүд Таныг илүү их таньж мэдэхэд зүрх сэтгэлээ нээх болтугай. (Марк 5:36)
24. Португалийн үйлчлэлийн багт мэргэн ухаан, удирдамж өгөөч, Эзэн минь. Тэдгээрийг ашиглан үгээ хуваалцаж, эмэгтэйчүүдэд Таны доторх өөрийнхөө жинхэнэ дүр төрхийг олоход нь туслаач. (Сур. 4:6-7)
25. Бурхан минь, Польшид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж, тэдэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зөв шударга удирдагчдыг босгож өгөөч. (Иохан 15:12)
26. Норвегид 16-19 насны дөрвөн охин тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Эзэн минь, охидыг энэ хүчирхийллээс хамгаалж, тэдний зүрх сэтгэлийн шарх болон биемахбодийг нь Та эдгээгээч. (Ис. 41:10)
27. Аав аа, Албани дахь Найдвар доторх эмэгтэйчүүд баг улс орныхоо шинэ үед хэрхэн хүрч үйлчлэх мэргэн ухааныг Та өгөөч. (Сур. 11:30)
28. Аав аа, Та биднийг эхийн хэвлийд урнаар шаглаж, Бид таны дүр төрхөөр гайхалтай бөгөөд аймшигтай бүтээгдсэн гэдгийг Дани улсын хууль тогтоогчид амьдралыг харах өнцөгөө болгоход нь туслаарай. (Дуу. 139:13-15)
29. Эзэн минь, Европын удирдагчид болон хууль тогтоогчдод мэргэн ухааныг өгөөч. Тэд биеэ үнэлэхтэй холбоотой хууль тогтоомжийг баталснаар олон улс орнуудад хүн худалдаалах болоон бэлгийн мөлжлөгийн эрэлт багасна хэмээн найдаж байна. (1 Тим. 2:1-4)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2024 оны УИХ-ын сонгуулиар бурхнаас эмээсэн удирд агчид гарч ирж, нийгэмд шударга ёс, тэгш байдлыг бий болгож, бүх хууль ард түмнийхээ төлөө батлагда х болтугай.
2. Гэр бүл салалтын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Залуучууд амьдралынхаа зөв сонголт, үр хүүхэд нь б үрэн бүтэн гэр бүлд өсөж торниход
3. Гэр бүлээ тэжээх гэж зовж буй өрх толгойлсон эхчүүд эд зориулав. Бурхан тэдний дуу хоолойг сонсож, тэдн ий хүч чадал, хамгаалагч, тайтгарал байх болтугай.

Хувьанна

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.